



## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

# ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Улаанбаатар  
2018 он

Эрүүл мэндийн яамны мэдээгээр 2016 онд улсын хэмжээнд 16181 хүн нас барж, нас баралтын эхний 7 шалтгаан (олон улсын өвчний ангилал -ICD10)-д элэг, цөс, зүрх судасны өвчлөл, элэг цөс, ходоодны хорт хавдар болон тархины цус харвалт зэрэг өвчлөлийн шалтгаан орж, нийт нас баралтын 49.5 хувийг эзэлж байгаа бол 8-д санаатайгаар амиа хорлосон гэсэн шалтгаан орж, нийт нас баралтын 2.8 хувийг эзэлж байна. Өвчлөлийн бус, гадны шалтгаан болох амиа хорлолт нь нас баралтын тэргүүлэх шалтгаануудад багтаж байгаа учраас үүнтэй холбоотой олон жилийн мэдээллийг, нас, хүйсээр нарийвчлан авч үзлээ.

Зураг 1. Нас барсан хүний тоо, эхний 11 шалтгаан, ОУ-ын өвчний дэлгэрэнгүй ангилал /ICD10/\*-аар, 2016 оны байдлаар

1	1,740	Элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн /C22/
2	1,641	Зүрхний ишемит өвчин /I20, I24, I25/
3	1,483	Тархины цус харвалт /I61, I62/
4	867	Зүрх судасны тогтолцооны бусад өвчин /I26-I28, I30-I52, I65-I69, I71-I89, I95-I99/
5	838	Зүрхний цочмог шигдээс /I21, I22, I23/
6	728	Элэгний фиброз ба цирроз /K74/
7	708	Ходоодны өмөн /C16/
8	450	Амиа хорлолт
9	429	Пневмони /J12-J18/
10	410	Спиртэнд санамсаргүй хордох, өртөх /X45/
11	355	Перинаталь үеийн амьсгалын ба зүрх судасны тогтолцооны өвөрмөц эмгэг /P20-P29/

Эх үүсвэр: ЭМЯ

Дэлхий нийтэд жил бүр 800 000 орчим хүн амиа хорлож, 40 секунд тутамд нэг хүн амиа хорлохыг завдах тохиолдол гардаг байна. Амиа хорлох нь 15-29 насныхны дунд үхлийн хоёр дахь шалтгаан болж байгаа төдийгүй дэлхийн хэмжээнд 2015 онд нас барсан нийт хүн амын 1.4 хувийг эзэлж байна. Мөн 2015 онд нийт амиа хорлосон хүн амын 78 хувь нь бага болон дунд орлоготой улсуудад байна<sup>1</sup>.

Нас баралтын түвшин буюу нас баралтын ерөнхий/насны бүлгээрх коэффициентийг 1000 хүнд ногдохоор, үүнийг нарийвчлан шалтгаанаар тооцох үед 100,000 хүнд ногдохоор тооцдог бөгөөд харин улс, бүс нутгаар харьцуулах үүднээс насны бүлгээр стандартчилан тооцох арга байдаг. Энгийнээр тайлбарлавал, хүн амын насны бүтэц улс, орон, бүс нутаг, байршил зэргээр ялгаатай учраас нас баралтын түвшинг шууд харьцуулан тайлбарлах нь учир дутагдалтай юм. Тиймээс насны бүтцийн ялгаатай байдлын нөлөөллийг арилгах зорилгоор шууд болон шууд бусаар засварлах арга техникийг ашигладаг байна. Дэлхийн эрүүл мэндийн

<sup>1</sup> [http://www.who.int/mental\\_health/prevention/suicide/suicideprevent/en/](http://www.who.int/mental_health/prevention/suicide/suicideprevent/en/)

байгууллагаас 183 улсын мэдээллийг ашиглан уг аргаар тооцсон 100,000 хүнд ногдох амиа хорлолтын түвшнээр 2015 онд 1-рт Шри Ланка (34.6), 2-рт Гайана (30.6), 3-рт Монгол Улс (28.1) эрэмбэлэгдэж байна<sup>2</sup>.

Манай улсын хувьд амиа хорлосон тохиолдлын талаар Эрүүл мэндийн яам болон Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл байдаг бөгөөд эдгээр 2 эх үүсвэрийн мэдээлэл зөрүүтэй байдаг. Энэхүү зөрүү нь эдгээр байгууллагын тухайн тохиолдлыг бүртгэх байдлаас шалтгаалж байна. Тухайлбал, ЭМЯ-ны хувьд нас баралтын тохиолдол бүрийг өвчний олон улсын ангилал, кодыг ашиглан шалтгаанаар бүртгэдэг. Харин Цагдаагийн ерөнхий газар “бусдыг амиа хорлоход хүргэсэн нь тогтоогдсон, үүний улмаас амиа хорлосон” гэсэн тохиолдлыг гэмт хэрэгт хамруулан бүртгэдэг байна.

Сүүлийн 15 жилийн хугацаанд жилд дунджаар 16 орчим мянган хүн нас барснаас 438 буюу 3% орчим хувь нь амиа хорлон нас баржээ. Эндээс жилд дунджаар 33 минут тутамд 1 хүн нас барж, 20 цаг тутамд 1 хүн амиа хорлон эндсэн гэж хэлж болох юм.

Хүснэгт 1. Нас барсан хүний тоо, хүйсээр, 2002-2016 он

ОН	Нас баралт					
	НИЙТ	Амиа хорлосон	Эрэгтэй	Амиа хорлосон	Эмэгтэй	Амиа хорлосон
2002	14,933	340	8,516	272	6,417	68
2003	15,130	223	8,804	198	6,326	25
2004	15,295	440	9,190	373	6,105	67
2005	15,469	448	9,466	379	6,003	69
2006	15,665	479	9,508	414	6,157	65
2007	15,752	517	9,764	449	5,988	68
2008	15,115	408	8,981	359	6,134	49
2009	15,522	443	9,148	351	6,374	92
2010	17,276	462	10,325	386	6,951	76
2011	17,127	444	10,571	374	6,556	70
2012	16,923	482	10,452	406	6,471	76
2013	16,192	465	9,733	397	6,459	68
2014	16,495	494	9,937	407	6,554	87
2015	16,374	479	9,822	408	6,552	71
2016	16,181	450	9,662	387	6,519	63
<b>2002-2016 оны дундаж</b>	<b>15,963</b>	<b>438</b>	<b>9,592</b>	<b>371</b>	<b>6,371</b>	<b>68</b>

Эх үүсвэр: ЭМЯ

Хүйсээр авч үзвэл, 2002-2016 оны дунджаар нийт нарсан хүн амын 60 хувь, харин амиа хорлогчдын 85 хувь нь эрэгтэйчүүд байна.

<sup>2</sup><http://apps.who.int/gho/data/view.main.MHSUICIDEASDRV?lang=en>

Амиа хорлогчдын тоо 2016 онд 450 болж, өмнөх оноос 29-өөр буюу 6.1 хувиар буурч, нийт нас баралтын 2.8 хувийг эзэлж байна.

Нийт нас барсан хүнд эзлэх амиа хорлогчдын хувь бага хэдий ч насны бүлэгт эзлэх хувийг тооцвол ялгаатай дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал, 2016 онд нас барсан 10-14 болон 25-29 насны 5 хүн тутмын 1, 15-24 насны 4 хүн тутмын 1, 30-34 насны 6 хүн тутмын 1 нь амиа хорлон нас барсан байна.

Хүснэгт 2. Амиа хорлогчдын нийт нас баралтад эзлэх хувь, насны бүлгээр, 2002-2016 он


Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүгд	2.28	1.47	2.88	2.90	3.06	3.28	2.70	2.85	2.67	2.59	2.85	2.87	2.99	2.93	2.78
0-4	0.0	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5-9	0.6	2.0	0.0	1.1	1.1	1.6	0.8	1.6	1.0	1.2	1.2	2.2	0.0	0.9	2.8
10-14	3.8	3.3	9.8	8.3	7.3	6.6	13.0	17.4	14.3	15.2	17.6	13.3	21.4	15.0	21.2
15-19	17.2	9.4	19.7	19.5	15.4	17.5	17.7	20.6	23.3	18.8	21.4	20.8	25.3	24.5	23.5
20-24	17.4	9.1	17.9	17.1	16.1	15.7	17.2	14.6	20.7	16.9	20.0	21.7	19.4	25.6	23.3
25-29	11.3	8.5	13.1	14.6	14.1	18.4	14.9	17.4	16.6	16.3	19.2	20.4	19.4	23.3	19.2
30-34	7.4	6.7	9.4	9.9	12.1	11.7	9.8	13.2	12.1	9.9	8.9	11.5	16.9	13.9	15.3
35-39	5.1	3.1	6.2	7.3	7.7	8.8	7.4	8.7	7.0	6.3	7.2	8.3	7.9	9.2	8.3
40-44	3.6	2.9	4.9	3.9	5.3	4.9	4.4	5.0	3.8	4.2	4.7	4.7	4.9	5.0	4.5
45-49	3.0	1.8	2.9	2.9	2.6	2.8	2.7	2.6	2.1	2.1	2.3	3.1	2.5	2.8	3.1
50-54	1.1	0.7	1.4	1.5	2.3	1.9	1.7	1.7	1.3	1.6	2.0	2.0	1.8	1.9	1.2
55-59	1.6	0.3	1.4	1.0	1.1	1.4	0.7	1.3	0.3	0.9	0.4	1.2	0.9	0.6	1.3
60-64	0.5	0.3	0.7	0.6	0.8	1.3	0.3	0.5	0.2	0.3	0.3	0.2	0.4	0.3	0.4
65+	0.2	0.0	0.2	0.1	0.3	0.2	0.1	0.2	0.1	0.2	0.1	0.2	0.3	0.1	0.1

Эх үүсвэр: ЭМЯ

Дээрх хүснэгтээс харахад, 2002 онд 10-14 насныхны амиа хорлолт энэ насны хүүхдүүдийн нийт нас баралтын 3.8 хувийг эзлэж байсан бол 2016 онд 21.2 хувь болж, 5 дахин өссөн нь бусад насны бүлэгтэй харьцуулбал хамгийн их өөрчлөлттэй бүлэг байна.

Нас барсан, эрэгтэй хүн амд амиа хорлогчдын эзлэх хувь 20-24 насанд өндөр байгаа хандлага 2016 онд хэвээр байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд 2002 онд 15-19 насанд хамгийн өндөр байснаа 2016 онд 10-14 насныхан болж, залуужсан байна.

Зураг 2. Амиа хорлогчдын нийт нас баралтад эзлэх хувь, хүйс, насны бүлгээр, 2002, 2010, 2016 он



# НАС БАРАЛТЫН ШАЛТГААН



## 10-14 НАСНЫХАН

- Тэргүүлэх 3 шалтгаан:
  1. АМИА ХОРЛОЛТ
  2. Мэдрэлийн тогтолцооны бусад өвчин
  3. Өмөн
- Амиа хорлогчдын 54.2% нь эрэгтэйчүүд



## 15-19 НАСНЫХАН

- Тэргүүлэх 3 шалтгаан:
  1. АМИА ХОРЛОЛТ
  2. Мэдрэлийн тогтолцооны бусад өвчин
  3. Тээврийн бусад осол
- Амиа хорлогчдын 75.6% нь эрэгтэйчүүд



## 20-24 НАСНЫХАН

- Тэргүүлэх 3 шалтгаан:
  1. АМИА ХОРЛОЛТ
  2. Тээврийн бусад осол
  3. Хүчирхийлэл, бусдад хорлогдох
- Амиа хорлогчдын 86.8% нь эрэгтэйчүүд



## 25-29 НАСНЫХАН

- Тэргүүлэх 3 шалтгаан:
  1. АМИА ХОРЛОЛТ
  2. Өмөн
  3. Тээврийн бусад осол
- Амиа хорлогчдын 87.9% нь эрэгтэйчүүд



## 30-34 НАСНЫХАН

- Тэргүүлэх 3 шалтгаан:
  1. АМИА ХОРЛОЛТ
  2. Өмөн
  3. Спиртэнд санамсаргүй хордох, өртөх
- Амиа хорлогчдын 91.9% нь эрэгтэйчүүд.




## 35-39 НАСНЫХАН

- Тэргүүлэх 3 шалтгаан:
  1. Өмөн
  2. Спиртэнд санамсаргүй хордох, өртөх
  3. АМИА ХОРЛОЛТ
- Амиа хорлогчдын 89.6% нь эрэгтэйчүүд

Түүнчлэн нас барсан хүн амыг насны бүлэг болон шалтгаанаар авч үзвэл ялангуяа өсвөр үе, залуучуудын дунд амиа хорлолт тэргүүлж байгаа төдийгүй тэдгээрийн дийлэнх нь эрэгтэйчүүд байна. Тухайлбал, амиа хорлон эндсэн 10-14 насныхны 54.2 хувь, 15-19 насныхны 75.6 хувь, 20-24 насныхны 86.8 хувь, 25-29 насныхны 87.9 хувь, 30-34 насныхны 91.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээс гадна ҮСХ нь 2014 оноос эхлэн жилийн эцсийн “Нийгмийн зарим үзүүлэлт”-ийн мэдээллээр амиа хорлох оролдлого хийсэн 18 хүртэлх насны хүүхдийн тоог нэгтгэн гаргаж байна. Энэхүү мэдээллээр 2017 онд амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд 19 байгаа нь өмнөх оноос 9-өөр буурсан байна. Сүүлийн 4 жилд нийтдээ 132 хүүхэд амиа хорлох оролдлого хийснээс 19.7 хувь нь Хөвсгөл, 14.4 хувь нь Увс, 10.6 хувь нь Төв аймаг болон Улаанбаатар хотод ногдож байна. Харин энэ хугацаанд Архангай, Баян-Өлгий, Булган, Дундговь, Говьсүмбэр аймгуудад уг тохиолдол бүртгэгдээгүй байна.

Зураг 3. Сүүлийн 4 жилд амиа хорлох оролдлого хийсэн 18 хүртэлх насны нийт хүүхдийн тоо, аймаг, нийслэлээр



### Дүгнэлт

Олон улсын өвчний ангилал(ICD10)-аар санаатайгаар амиа хорлолт нь “Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан /V00-Y99/” гэсэн ангилалд санамсаргүй осол, тээврийн осол зэрэгтэй нэгтгэгдэн мэдээлэгддэг учраас төдийлөн анхааралд өртөхгүй үлдэх болжээ.

Дэлхийн түвшинд 28 улс амиа хорлохоос сэргийлэх, хамгаалах стратеги хэрэгжүүлж байна. Улс, орны туршлагаас харахад амиа хорлохоос сэргийлэх, хянах зорилгоор амиа хорлох арга замыг багасгахад галт зэвсэг, эмийн хэрэглээг хянах, хязгаарлах; архи, согтууруулах ундааны хэрэглээг багасгах бодлого хэрэгжүүлэх;

эмийн хэрэглээнээс хамааралтай болон сэтгэцийн хямралтай хүмүүсийг эрт илрүүлж, эмчлэх; мэргэшсэн эрүүл мэндийн ажилтнууд болон сэтгэл зүйчдийг бэлтгэх; амиа хорлохыг оролдсон хүмүүсийг анхаарч, туслах, олон нийтийн дэмжлэг үзүүлэх зэрэг арга, хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

Нас баралтын тэргүүлэх шалтгаан нь улсын хэмжээнд халдварт бус болон халдварт өвчлөл байгаа хэдий ч гадны шалтгаан, тэр дундаа амиа хорлолт нь өсвөр үе болон залуучуудын дунд өндөр, тэргүүлэх шалтгаан болж байна.

Энэ нь амиа хорлох болсон сэдэл, шалтгааныг нас, хүйсийн онцлогоос хамааруулан нарийвчлан тодорхойлж, эрсдэл бүхий бүлгийг тогтоон, түүнд тохирох арга хэмжээг авах шаардлагатайг харуулж байна.

Өсвөр үе болон залуучуудын сэтгэл зүй, зан байдал, амьдарч буй орчин, гэр бүлийн харилцаанд илүү анхаарал хандуулж, хүүхэд хамгаалал, залуучууд, гэр бүлийн тухай зэрэг холбогдох хууль, тогтоомж, хөтөлбөрүүдэд амиа хорлохоос хамгаалах талаар тодорхой тусгаж, хэрэгжүүлэх, тухайлбал, ерөнхий боловсролын сургуулийг мэргэшсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээр ханган, өсвөр үе, хүүхдүүдэд зөвлөгөө, тусламж авах боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## Хүснэгт 1. Нас барсан хүний тоо, насны бүлэг, хүйсээр, 2002-2016 он

Улс															
Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
<b>Бүгд</b>	<b>14,933</b>	<b>15,130</b>	<b>15,295</b>	<b>15,469</b>	<b>15,665</b>	<b>15,752</b>	<b>15,115</b>	<b>15,522</b>	<b>17,276</b>	<b>17,127</b>	<b>16,923</b>	<b>16,192</b>	<b>16,495</b>	<b>16,374</b>	<b>16,181</b>
0-4	1,766	1,402	1,296	1,177	1,139	1,231	1,480	1,626	1,622	1,410	1,396	1,438	1,505	1,476	1,628
5-9	157	148	132	95	87	128	123	123	99	84	81	92	97	112	108
10-14	158	153	123	145	109	91	123	109	112	125	108	90	112	107	113
15-19	262	266	269	282	254	228	231	199	215	224	192	159	190	200	187
20-24	373	364	402	380	386	446	377	355	405	385	405	327	315	285	253
25-29	442	457	503	514	495	495	471	414	441	429	468	417	403	378	381
30-34	552	538	614	646	638	614	539	515	628	636	661	532	503	475	450
35-39	662	642	723	799	810	826	675	678	823	837	817	700	744	662	629
40-44	812	926	1,028	1,015	1,147	1,165	1,006	927	1,025	1,114	1,066	944	935	899	851
45-49	871	1,051	1,137	1,274	1,276	1,372	1,185	1,135	1,436	1,475	1,486	1,243	1,253	1,176	1,109
50-54	922	996	1,160	1,110	1,280	1,339	1,187	1,331	1,583	1,743	1,635	1,592	1,590	1,478	1,461
55-59	902	991	1,059	1,069	1,072	1,128	1,017	1,118	1,283	1,387	1,418	1,440	1,543	1,683	1,673
60-64	1,420	1,394	1,357	1,228	1,199	1,193	1,086	1,076	1,217	1,284	1,265	1,269	1,326	1,359	1,283
65+	5,634	5,802	5,492	5,735	5,773	5,496	5,615	5,916	6,387	5,994	5,925	5,949	5,979	6,084	6,055

Эрэгтэй															
Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
<b>Бүгд</b>	<b>8,516</b>	<b>8,804</b>	<b>9,190</b>	<b>9,466</b>	<b>9,508</b>	<b>9,764</b>	<b>8,981</b>	<b>9,148</b>	<b>10,325</b>	<b>10,571</b>	<b>10,452</b>	<b>9,733</b>	<b>9,937</b>	<b>9,822</b>	<b>9,662</b>
0-4	984	782	737	661	653	664	861	914	893	794	792	803	854	859	925
5-9	91	94	76	50	45	78	87	77	69	49	55	61	69	74	68
10-14	95	83	78	98	69	60	84	67	82	93	72	63	72	74	70
15-19	167	163	180	198	171	165	170	128	148	154	130	108	126	143	125
20-24	247	260	287	263	273	343	263	244	271	286	296	237	213	214	185
25-29	315	327	369	368	372	370	345	276	312	323	346	315	306	267	267
30-34	369	377	460	492	497	476	409	348	465	480	484	402	390	371	331
35-39	455	456	516	618	595	629	480	476	608	622	604	512	544	493	460
40-44	524	627	742	730	831	862	709	649	715	817	791	685	674	686	606
45-49	579	682	774	909	874	981	830	769	995	1,051	1,079	840	913	834	796
50-54	572	619	753	752	853	921	759	871	1,079	1,194	1,169	1,062	1,076	995	1,007
55-59	559	614	722	692	716	738	633	740	824	935	973	976	1,027	1,096	1,164
60-64	848	840	826	784	732	741	641	658	742	836	797	763	837	833	816
65+	2,711	2,880	2,670	2,851	2,827	2,736	2,710	2,931	3,122	2,937	2,864	2,906	2,836	2,883	2,842

Эмэгтэй															
Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
<b>Бүгд</b>	<b>6,417</b>	<b>6,326</b>	<b>6,105</b>	<b>6,003</b>	<b>6,157</b>	<b>5,988</b>	<b>6,134</b>	<b>6,374</b>	<b>6,951</b>	<b>6,556</b>	<b>6,471</b>	<b>6,459</b>	<b>6,554</b>	<b>6,552</b>	<b>6,519</b>
0-4	782	620	559	516	486	567	619	712	729	616	604	635	651	617	703
5-9	66	54	56	45	42	50	36	46	30	35	26	31	28	38	40
10-14	63	70	45	47	40	31	39	42	30	32	36	27	40	33	43
15-19	95	103	89	84	83	63	61	71	67	70	62	51	64	57	62
20-24	126	104	115	117	113	103	114	111	134	99	109	90	102	71	68
25-29	127	130	134	146	123	125	126	138	129	106	122	102	97	111	114
30-34	183	161	154	154	141	138	130	167	163	156	177	130	113	104	119
35-39	207	186	207	181	215	197	195	202	215	215	213	188	200	169	169
40-44	288	299	286	285	316	303	297	278	310	297	275	259	257	213	245
45-49	292	369	363	365	402	391	355	366	441	424	407	403	340	342	313
50-54	350	377	407	358	427	418	428	460	504	549	466	530	514	483	454
55-59	343	377	337	377	356	390	384	378	459	452	445	464	516	587	509
60-64	572	554	531	444	467	452	445	418	475	448	468	506	489	526	467
65+	2,923	2,922	2,822	2,884	2,946	2,760	2,905	2,985	3,265	3,057	3,061	3,043	3,143	3,201	3,213

Эх үүсвэр: ЭМЯ



## Хүснэгт 2. Амиа хорлон нас барсан хүний тоо, насны бүлэг, хүйсээр, 2002-2016 он

Улс

Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
<b>Бүгд</b>	<b>340</b>	<b>223</b>	<b>440</b>	<b>448</b>	<b>479</b>	<b>517</b>	<b>408</b>	<b>443</b>	<b>462</b>	<b>444</b>	<b>482</b>	<b>465</b>	<b>494</b>	<b>479</b>	<b>450</b>
0-4	0	0	1	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0
5-9	1	3	0	1	1	2	1	2	1	1	1	2	0	1	3
10-14	6	5	12	12	8	6	16	19	16	19	19	12	24	16	24
15-19	45	25	53	55	39	40	41	41	50	42	41	33	48	49	44
20-24	65	33	72	65	62	70	65	52	84	65	81	71	61	73	59
25-29	50	39	66	75	70	91	70	72	73	70	90	85	78	88	73
30-34	41	36	58	64	77	72	53	68	76	63	59	61	85	66	69
35-39	34	20	45	58	62	73	50	59	58	53	59	58	59	61	52
40-44	29	27	50	40	61	57	44	46	39	47	50	44	46	45	38
45-49	26	19	33	37	33	39	32	29	30	31	34	39	31	33	34
50-54	10	7	16	17	30	25	20	22	20	28	32	32	28	28	18
55-59	14	3	15	11	12	16	7	14	4	12	6	17	14	10	22
60-64	7	4	10	7	9	15	3	5	2	4	4	2	5	4	5
65+	12	2	9	6	15	11	6	13	9	9	6	9	15	5	9

Эрэгтэй

Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
<b>Бүгд</b>	<b>272</b>	<b>198</b>	<b>373</b>	<b>379</b>	<b>414</b>	<b>449</b>	<b>359</b>	<b>351</b>	<b>386</b>	<b>374</b>	<b>406</b>	<b>397</b>	<b>407</b>	<b>408</b>	<b>387</b>
0-4	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
5-9	0	2	0	1	1	1	1	1	0	1	1	2	0	1	3
10-14	5	4	10	8	7	6	11	15	14	16	12	9	17	12	13
15-19	31	24	42	46	26	33	39	27	37	31	34	27	38	36	33
20-24	48	31	58	47	48	58	56	38	66	50	66	53	42	63	52
25-29	43	32	58	67	64	80	63	55	61	61	78	76	68	75	64
30-34	36	34	50	52	68	67	50	59	65	58	47	53	74	59	63
35-39	32	18	40	51	56	65	45	46	54	46	52	52	52	52	47
40-44	24	23	48	37	58	50	37	37	35	41	44	41	38	39	36
45-49	20	16	27	32	26	29	26	25	25	28	30	33	28	29	29
50-54	8	6	13	16	29	22	16	19	17	21	28	30	24	24	15
55-59	11	2	14	9	10	15	6	13	4	10	6	14	10	9	21
60-64	6	4	8	7	7	14	3	4	1	4	3	2	5	4	5
65+	8	2	4	6	14	9	6	12	7	7	5	5	11	5	6

Эмэгтэй

Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
<b>Бүгд</b>	<b>68</b>	<b>25</b>	<b>67</b>	<b>69</b>	<b>65</b>	<b>68</b>	<b>49</b>	<b>92</b>	<b>76</b>	<b>70</b>	<b>76</b>	<b>68</b>	<b>87</b>	<b>71</b>	<b>63</b>
0-4	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0
5-9	1	1	0	0	0	1	0	1	1	0	0	0	0	0	0
10-14	1	1	2	4	1	0	5	4	2	3	7	3	7	4	11
15-19	14	1	11	9	13	7	2	14	13	11	7	6	10	13	11
20-24	17	2	14	18	14	12	9	14	18	15	15	18	19	10	7
25-29	7	7	8	8	6	11	7	17	12	9	12	9	10	13	9
30-34	5	2	8	12	9	5	3	9	11	5	12	8	11	7	6
35-39	2	2	5	7	6	8	5	13	4	7	7	6	7	9	5
40-44	5	4	2	3	3	7	7	9	4	6	6	3	8	6	2
45-49	6	3	6	5	7	10	6	4	5	3	4	6	3	4	5
50-54	2	1	3	1	1	3	4	3	3	7	4	2	4	4	3
55-59	3	1	1	2	2	1	1	1	0	2	0	3	4	1	1
60-64	1	0	2	0	2	1	0	1	1	0	1	0	0	0	0
65+	4	0	5	0	1	2	0	1	2	2	1	4	4	0	3

Эх үүсвэр: ЭМЯ

Хүснэгт 3. Амиа хорлох оролдлого хийсэн 18 хүртэлх насны хүүхдийн тоо, 2014-2017 он

Аймаг, нийслэл	Он				
	2014	2015	2016	2017	2014-2017
Нийт	<b>56</b>	<b>29</b>	<b>28</b>	<b>19</b>	<b>132</b>
Архангай	-	-	-	-	-
Баян-Өлгий	-	-	-	-	-
Баянхонгор	-	-	1	-	1
Булган	-	-	-	-	-
Говь-Алтай	-	1	-	4	5
Дорноговь	1	2	-	-	3
Дорнод	2	-	7	1	10
Дундговь	-	-	-	-	-
Завхан	1	-	-	-	1
Өвөрхангай	-	-	-	2	2
Өмнөговь	5	2	5	-	12
Сүхбаатар	2	1	-	-	3
Сэлэнгэ	4	-	3	2	9
Төв	7	3	1	3	14
Увс	5	10	3	1	19
Ховд	1	-	-	-	1
Хөвсгөл	15	9	-	2	26
Хэнтий	1	1	1	1	4
Дархан-Уул	-	-	2	-	2
Улаанбаатар	10	-	3	1	14
Орхон	2	-	2	2	6
Говьсүмбэр	-	-	-	-	-

Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ